



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 12 сарын 02 өдөр

Дугаар А/А67

Булган сум

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны XIX/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Усан шүүлтүүртэй халаалтын тогоо шинэчлэх 1.8 мвт (Хутаг-Өндөр сум) ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчээр шалгарсан "Бэсүжин констракшн" ХХК-тай 105,206,650 (нэг зуун таван сая хоёр зуун зургаан мянга зургаан зуун тавь) төгрөгөөр гэрээ байгуулж, холбогдох хууль, тогтоомж, гэрээний дагуу хяналт тавьж, хүлээн авахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Г.Давааням)-т үүрэг болгосугай.

2.Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг "Бэсүжин констракшн" ХХК-ийн захирал (Б.Батмагнай)-д үүрэг болгосугай.

3.Тус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэж хөрөнгө ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавихыг "Илчит хутаг" ОНӨХХК-ийн захирал (Я.Данзанчойжил)-д үүрэг болгосугай.

4.Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ЛҮРЭВ-ОЧИР



Сугар Ажил 2024 өдөр бүр Doc/2024/Захирамж

6324011135

Аймгийн Засаг даргын 2024 оны
12 дугаар сарын 03-ны ний өдрийн А/167 дугаар
захирамжийн хавсралт



д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Баталгаат хугацаа	12 сар	Д.Батцогт Я.Данзанчойжил
2	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь, чанарын баталгааг байршуулах банк, дансыг гэрээнд тусгана.	Д.Батцогт
3	Гүйцэтгэлийн баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 3 хувь	Д.Батцогт
4	Бараа нийлүүлэх хуваарь	Гэрээнд зааснаар	Г.Давааням